



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/133

Бор-Өндөр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бор-Өндөр сумын хэмжээнд “Хүүхдийн баяр”-ын арга хэмжээтэй холбогдуулан чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэх, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, зөрчил дутагдлыг таслан зогсоох зорилгоор Бор-Өндөр сумын хэмжээнд “Хүнсний худалдаа” эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч
Ц.Мөнхгэрэл

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо
хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга
Б.Бадамханд

Хууль, эрх зүйн мэргэжилтэн

Гишүүд
А.Өлзийсүрэн

Бэлчээр, газар тариалан хариуцсан
мэргэжилтэн

Р.Цэндсүрэн
А.Ихэрболд


Тархвар зүйч

Хэв журмын асуудал хариуцсан байцаагч,
Цагдаагийн дэслэгч

2. Хүүхдийн баяртай холбогдуулан хяналт, шалгалтын ажлын удирдамжийг хавсралтаар ёсоор баталсугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Ууганжаргал)-д, гүйцэтгэлийг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ГАДЪЯАБИЛЭГТ

D:/bichig hereg/Захирамж.docx